**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 22 өдөр Дугаар А/130 Арвайхээр

Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах тухай

Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, $19^1$ дүгээр зүйлийн $19^1$.1, $19^1$.3.1, $19^1$.3.2, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Агаарийн бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн хэрэгслийн 2021 оны автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сумдын салбар комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн ажлын хэсгийн дарга (И.Доржсүрэн)-д ДААЛГАХ нь:

а.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах ажлыг оновчтой зохион байгуулж, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах.

б.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах ажлыг саатуулсан, зайлсхийсэн буруутай албан тушаалтан, иргэнд хуулийн хариуцлага тооцож ажиллах.

в.Тогтоосон хугацаанд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, жолоочийн даатгалд даатгуулаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар төрийн холбогдох байгууллагуудад үүрэг өгч, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

3.Сумдын Засаг дарга нар болон сумдын салбар ажлын хэсгийн ахлагч нарт ДААЛГАХ нь:

а.Сумын иргэдийн өмчлөлд байгаа өөрийн аймгийн болон Улаанбаатар хотын улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг орон нутагт бүрэн шилжүүлж, татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

011100282

б.Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын дугааргүй замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклыг бүртгэлд хамруулж, дугааржуулах.

в.Сүүлийн 5 жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй улсын бүртгэлээс хасах шаардлагатай, өөрийн аймагт харьяалагдах тээврийн хэрэгслүүдийг улсын бүртгэлээс хасалт хийх ажлыг зохион байгуулах.

г.Тухайн нутаг дэвсгэртээ тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг зохион явуулах комиссын бүрэлдэхүүнийг байгуулж, хяналт тавьж ажиллах.

4.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хуулийн дагуу хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2021 оны 03
дугаар сарын 29-ны өдрийн А/260 дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

# ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР ХУРААХ, ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ АЙМГИЙН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга Д.Амартүвшин (Аймгийн Автотээврийн төвийн дарга)
Гишүүд: Н.Эрдэнэсувд (Аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн дарга)

Б.Бүрэнтөгс (Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга)

С.Дуламсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Б.Цэндсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч)

Б.Мөнхбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан ахлах мэргэжилтэн)

-oOo-

Аймгийн Засаг даргын 2021 оны 03
дугаар сарын 22-ны өдрийн А/130 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт

# ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР ХУРААХ, ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ СУМДЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга (Сумын Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Сумын хэсгийн төлөөлөгч болон цагдаагийн ажилтан

Татварын байцаагч

Багийн Засаг дарга нар

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны 03
дугаар сарын 22-ны өдрийн А/150 дугээр
захирамжийн гуравдугаар хавсралт

# СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ

| № | Сумдын нэрс | Сар өдөр | Ажиллах Хоног | Ажлын бүрэлдэхүүн |
|---|---|---|---|---|
| 1 | Арвайхээр | 01 дүгээр сарын 05-аас 4 дүгээр сарын 08 | *** | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 2 | Хайрхандулаан | 04 дүгээр сарын 12,13,14 | 3 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 3 | Тарагт | 04 дүгээр сарын 15,16 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 4 | Уянга сумын Жаргалант баг | 04 дүгээр сарын 17,18 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 5 | Уянга | 04 дүгээр сарын 19,20,21,22 | 4 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 6 | Бат-Өлзий | 04 дүгээр сарын 23,24,25,26,27,28 | 6 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 7 | Хужирт | 04 дүгээр сарын 29,30 5 дугаар сарын 01,02,03 | 5 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 8 | Хархорин | 05 дугаар сарын 04, 05, 06, 07, 08, 09, 10, 11, 12, 13, 14 | 11 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 9 | Зүүнбаян-Улаан | 05 дугаар сарын 15,16 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 10 | Арвайхээр | 05 дугаар сарын 19,20 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 11 | Бүрд | 05 дугаар сарын 21,22 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 12 | Есөнзүйл | 05 дугаар сарын 23,24 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 13 | Өлзийт | 05 дугаар сарын 25,26 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14 | Баян-Өндөр | 05 дугаар сарын 27,28,29 | 3 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 15 | Сант | 05 дугаар сарын 30,31 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 16 | Баянгол | 06 дугаар сарын 02,03 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 17 | Төгрөг | 06 дугаар сарын 04,05 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 18 | Гучин-Ус | 06 дугаар сарын 06,07 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 19 | Богд | 06 дугаар сарын 10,11,12 | 3 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 20 | Баруунбаян-Улаан | 06 дугаар сарын 13,14 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 21 | Нарийнтээл сумын Баянтээг баг | 06 дугаар сарын 15,16 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 22 | Нарийнтээл | 06 дугаар сарын 17,18 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 23 | Арвайхээр | 06 дугаар сарын 21-ээс 12 дугаар сарын 25 дуустал | **** | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |

-oOo-